

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ГУЧИНЕСДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны арванхоёрдугаар сарын 08-ны 14 цаг 15 минутад эхэлж, 16 цаг 14 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 59 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Нээлттэй сонгон шалгаруулалтаар төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах Комиссын товч тайлан танилцуулах	
2	Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32 дугаар зүйл, Сонгон шалгаруулах комиссын 2016 оны НСШ/52 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Дүгэрсүрэнгийн Эрдэнэцэцэгийг Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Пүрэвхагвад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
3	Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32 дугаар зүйл, Сонгон шалгаруулах комиссын 2016 оны НСШ/53 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус</p>

		<p>үндэслэн:</p> <p>Лхамтогмидын Нямгэрэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгаланд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
4	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ХЭГ/2027 тоот албан бичгээр ирүүлсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2017 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
5	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ХЭГ/2027 тоот албан бичгээр ирүүлсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2017 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
6	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ХЭГ/2027 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2017 оны 1 дүгээр</p>

		сарын 06-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
7	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга, Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга, Мэдээллийн, технологийн газрын дарга зэрэг албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогтын 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 1-4/1636 тоот албан бичгээр ирүүлсэн Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2017 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүүгийн 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 1/12091 тоот албан бичгээр ирүүлсэн Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын даргын, Мэдээллийн технологийн газрын даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2017 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
8	Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайханы 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн в/3043 тоот албан бичгээр ирүүлсэн Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2017 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
9	Говьсүмбэр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Батзамын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 369 тоот албан бичгээр ирүүлсэн Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй</p>

		<p>сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2017 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
10	<p>Булган аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, 2016 оны 12 дугаар сарын 01,02-ны өдрүүдэд Булган аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 08 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1.Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 82 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 22 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2.Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан гуравдугаар хавсралтад дурдсан нэр бүхий 12 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 4 иргэн, нийт 16 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 16 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг</p>

		<p>баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлд үүрэг болгох</p> <p>4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
--	--	--

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**